

## Нэхэмжлэх ба төлбөр барагдуулалтын журам

### 1. ЖУРАМ:

- NorthShore – Edward-Elmhurst (NS-ЕЕН) эрүүл мэндийн системийн үндсэн зорилго нь NS-ЕЕН системээр үйлчлүүлдэг, тухайн харьяа газарт орших суух хувь хүмүүс, өрхүүдийн хэрэгцээг хангахуйц чанартай, үр дүнтэй эрүүл мэндийн асаргаа, тусламж үйлчилгээ, эрүүл мэндтэй холбоотой бусад үйлчилгээг үзүүлэх юм. Энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгоор NS-ЕЕН систем дараах ашгийн бус эмнэлгүүдтэй хамтран ажилладаг: Evanston Hospital, Glenbrook Hospital, Highland Park Hospital, and Skokie Hospital (хамтад нь NorthShore”(NS) гэх), Swedish Hospital, Northwest Community Hospital (NCH), Edward Hospital, Elmhurst Hospital, Linden Oaks Behavioral Health (хамтад нь “ЕЕН” гэх). Тодорхой эмнэлгүүдэд хамаарах журмууд зөрүүтэй байх тохиолдолд тус тусад нь тодорхойлно.
- Энэхүү журамд NS-ЕЕН-ийн өвчтөнүүдэд үзүүлсэн үйлчилгээнүүдтэй холбогдуулан төлбөртэй үйлчилгээний төлбөр ба эмч нарын төлбөрийг барагдуулахын тулд NS-ЕЕН-ийн зүгээс авах арга хэмжээнүүдийг дурдсан болно. Мөн тус журам нь төлбөр барагдуулахтай холбоотой үйл явц, хугацаа, төлбөр төлөөгүй тохиолдолд NS-ЕЕН-ийн зүгээс авах арга хэмжээ, өвчтөн санхүүгийн тусламжавах шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд NS-ЕЕН-ийн зүгээс авч хэрэгжүүлэх ёстой бодит арга хэмжээнүүдийг тодорхойлно.
- Энэхүү журамд NS-ЕЕН-ээс үзүүлсэн үйлчилгээний төлбөрийн төлөгдөөгүй нийт дүнтэй холбогдуулан NS-ЕЕН-ийн зүгээс өвчтөнүүдтэй хэрхэн харилцах талаар тусгасан.
- Мөн түүнчлэн энэхүү журамд NS-ЕЕН-ийн зүгээс өвчтөний тооцоог найдваргүй авлагад тооцох нөхцөлүүд болон өвчтөний тооцоонуудын хасах бичилтийг хянах үйл явцыг тодорхойлно.
- NS-ЕЕН нь Дотоод орлогын кодын 501(г) хэсэгт заасан Төлбөр барагдуулах тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхгүй.
- Энд дурдсан журам, үйл ажиллагаанууд нь Иллиной муж улсын дүрэм журмууд, Дотоод орлогын кодын 501(г) хэсэг, холбогдох удирдамжид нийцсэн болно.
- NS-ЕЕН нь NorthShore Нэгдсэн тооцооны алба (Single Billing Office), Swedish Hospital Санхүүгийн үйлчилгээний төв, NCH Санхүүгийн зөвлөх, ЕЕН Санхүүгийн тусламжийн хэлтсээс санхүүгийн тусламж авах эрхтэй эсэхийг тодорхойлохын тулд боломжит хүчин чармайлт гарган ажилласан эсэхийг тодорхойлох эрхтэй байна.

### 2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү журам нь NS-ЕЕН-ийн өвчтөнүүдэд үзүүлсэн үйлчилгээний төлбөртэй үйлчилгээний ба эмч нарын төлбөрийн үлдэгдэл, тооцоонуудад хамаарна.

### 3. ТОДОРХОЙЛОЛТ:

Гэрээний залруулга – Үйлчилгээний тогтсон дүнгээр тооцож гаргасан өвчтөний нийт төлбөр ба гэрээний зохицуулалт болон бодлогын дагуу гуравдагч этгээдээс ирүүлэх бодит нөхөн төлбөрийн зөрүүг тусгахын тулд өвчтөний тооцоонд оруулах залруулга, тохируулах бичилтийг ойлгоно.

Найдваргүй авлагаас хасах – Төлж барагдуулахааргүй, барагдуулах боломжгүй хэмээн тооцсон төлбөрийн дүнгийн хувьд өвчтөний тооцоог найдваргүй авлагаас хасдаг боловч өвчтөн үлдэгдэл төлбөрийг төлөх үүрэгтэй байна. Төлбөр барагдуулах тогтсон шалгуур үзүүлэлтийг ашиглан энэхүү тодорхойлолтыг гаргах бөгөөд зөвхөн төлбөр тооцоотой холбогдуулан нэхэмжлэх гаргаж, төлбөр барагдуулах дараа дараачийн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа л ийнхүү тооцооноос хасна.

Өргөдөл – Өвчтөний бөглөх санхүүгийн тусламж авах тухай өргөдлийг ойлгоно.

Өргөдөл гаргах хугацаа – Өргөдөл гаргах хугацааны турш NS-ЕЕН санхүүгийн тусламж авах өргөдлийг хүлээн авч, боловсруулна. Өргөдөл гаргах хугацаа хувь хүнд асаргаа үйлчилгээ үзүүлсэн өдрөөс эхэлж үзүүлсэн асаргаа үйлчилгээний эхний нэхэмжлэх ирсэн өдрөөс хойш 240 дэх хоног дээр дуусна.

Санхүүгийн тусламж – Санхүүгийн тусламж гэдэг нь NS-ЕЕН системийн Санхүүгийн тусламжийн журамд (СТЖ) тодорхойлсноор санхүүгийн болон бусад төрлийн тусламж авах эрхийн шалгуур үзүүлэлтийг хангасан өвчтөнүүд эмнэлгийн байгууламж дотор NS-ЕЕН системийн зүгээс үзүүлсэн чухал шаардлагатай болон яаралтай эрүүл мэнд асаргааны тусламж үйлчилгээнийхээ төлбөрийг төлөхөд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг олж авахад нь туслах зорилгоор NS-ЕЕН-ээс санал болгодог тусламж юм. Эрхийн шалгуур үзүүлэлтийг хангасан өвчтөнүүдэд даатгалд хамрагдаагүй, бага орлоготой өвчтөнүүд, хэсэгчилсэн даатгалд хамрагдсан боловч эмнэлгийн төлбөрийн үлдсэн хэсгийг эсвэл бүхэлд нь төлж чадахгүй байгаа өвчтөнүүдийг хамруулан ойлгоно.

Төлбөр барагдуулах тусгай арга хэмжээ (ТБТАХ) – Эдгээр нь хууль эрх зүйн эсвэл шүүхийн үйл явц шаардсан болон өр төлбөрийг өөр нэг этгээдэд зарах эсвэл зээл олгох байгууллагууд эсвэл товчоодод сөрөг мэдээлэл тайлагнах гэх мэт бусад үйл ажиллагааг хамарсан төлбөр барагдуулах үйл ажиллагаанууд юм. NS-ЕЕН-ийн зүгээс ийм ТБТАХ-д оролцдоггүй бөгөөд төлбөр барагдуулах ажилтнууддаа ч ТБТАХ-ийг авч хэрэгжүүлэхийг зөвшөөрдөггүй.

Хангалттай хүчин чармайлт – NS-ЕЕН нь СТЖ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйг өвчтөнд санал болгож, NS-ЕЕН СТЖ-ийн талаар тодорхой мэдээлэл хүргэхийн тулд хангалттай хүчин чармайлт гаргана. Мөн түүнчлэн өвчтөнүүдэд NS-ЕЕН СТЖ-ын талаар мэдээлэл өгөхийн тулд NS-ЕЕН дараах алхамуудыг хийж гүйцэтгэнэ.

Энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй – NS-ЕЕН системийн СТЖ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйд: 1) тавигдах шаардлагууд болон санал болгосон тусламжийн товч тодорхойлолт; 2) санхүүгийн тусламж авах өргөдлийг хүлээн авах вебсайт болон газруудын байршлын жагсаалт; 3) СТЖ-ын хэвлэмэл хувийг хэрхэн үнэ төлбөргүй авах зааварчилгаа; 4) өргөдөл гаргах явцад шаардлагатай тусламж авахад шаардагдах холбоо барих мэдээлэл; 5) СТЖ болон холбогдох бичиг баримтуудыг ямар хэлүүдээр орчуулсан талаарх мэдээлэл; 6) санхүүгийн тусламж авах эрхтэй хэмжээн тодорхойлогдсон өвчтөнд яаралтай тусламжийн эсвэл эмнэлгийн шаардлагатай үйлчилгээнд НЕД-гээс хэтрэхгүй дүнгээр төлбөр тооцохыг баталгаажуулсан мэдэгдэл багтана.

- 1) Өргөдлийг дутуу бөглөх – Хэрэв өвчтөн/өвчтөний гэр бүлийн гишүүн санхүүгийн тусламж хүссэн өргөдлийг бүрэн бус, дутуу бөглөж өгвөл NS-ЕЕН шаардагдах нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг тодорхойлсон мэдэгдлийг бичгээр гаргаж өгнө.
- 2) Өргөдлийг бүрэн бөглөх – Хэрэв өвчтөн/өвчтөний гэр бүлийн гишүүн санхүүгийн тусламж хүссэн өргөдлийг бүрэн бөглөж өгвөл NS-ЕЕН тухайн өвчтөн санхүүгийн тусламж авах эрхтэй эсэхийг тодорхойлох мэдэгдлийг цаг тухайд нь бичгээр гарган өгч, тухайн өвчтөнд энэ шийдвэр (мөн боломжтой бол, тухайн өвчтөний авч болох тусламжийн тухай) болон шийдвэрийг гаргасан үндэслэлээ бичгээр мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд мөн санхүүгийн тусламжийн хувиар тооцсон дүн (зөвшөөрөгдсөн өргөдлийн хувьд) эсвэл татгалзсан шалтгаан, өвчтөн ба гэр бүлээс нь төлөх төлбөрийн дүнг оруулна. Бөглөсөн өргөдлийг үнэлэх явцад өвчтөн болон түүний гэр бүл өвчтөнд илгээх мэдэгдлийг үргэлжлүүлэн хүлээж авна.
- 3) Өвчтөнд мэдэгдэл ирүүлэх – NS-ЕЕН нь өвчтөнд тухайн өвчтөний тооцоо ба төлөх ёстой дүнг дурдсан хэд хэдэн мэдэгдэл илгээнэ. Өвчтөнд ирүүлэх мэдэгдэлд тухайн өвчтөн өөрийн хамрагдсан аливаа эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг NS-ЕЕН-д мэдэгдэх үүрэгтэйг сануулсан бичиг, NS-ЕЕН СТЖ-ын талаарх мэдэгдэл, санхүүгийн тусламж хүсэх утасны дугаар, санхүүгийн тусламж хүсэхэд шаардагдах бичиг баримтуудыг авч болох вебсайтын хаягууд багтана.
- 4) NS-ЕЕН-ийн вебсайт – NS-ЕЕН нь вебсайтаа санхүүгийн тусламж авах боломжтой талаарх мэдээллийг санхүүгийн тусламж хүсэх өргөдөл гаргах үйл явцын талаарх тайлбарын хамт харагдахуйц газар байрлуулна. NS-ЕЕН нь [northshore.org/about-us/billing/financial-assistance](http://northshore.org/about-us/billing/financial-assistance) эсвэл [swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance](http://swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance) эсвэл [nch.org/billing-insurance/financial-assistance](http://nch.org/billing-insurance/financial-assistance) эсвэл [ehealth.org/patients-visitors/manage-my-costs-and-billing/billing/financial-assistance](http://ehealth.org/patients-visitors/manage-my-costs-and-billing/billing/financial-assistance) вебсайтуудад өөрийн СТЖ–ыг СТЖ-д хамрагдсан болон хамрагдаагүй үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалт, энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй, санхүүгийн тусламж хүсэх өргөдөл, нэхэмжлэх ба төлбөр барагдуулалтын журмын хамт нийтэлнэ. NS-ЕЕН-д эдгээр бичиг баримтыг хүсэлт гаргасны үндсэн дээр хэвлэмэл хувиудыг NorthShore (847) 570-5000, Swedish Hospital-оос (773) 989-3841 (847), NCH-ээс (847) 618-4542, ЕЕН-ээс (866) 756-8348 дугаарын утсаар холбогдож, шуудангаар авах боломжтой.

#### 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- A. *Өвчтөнтэй харилцах нь*: Орлогын эргэлтийн аль болох эхээр өвчтөнүүдэд тэдний төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл, мөн NS-ЕЕН-ийн төлбөрийн төлөвлөгөөтэй холбогдох мэдэгдлийг бичгээр эсвэл аман хэлбэрээр ирүүлнэ. Өвчтөнтэй харилцах бүх харилцаанд санхүүгийн тусламжийн хүртээмжтэй байдлын талаарх мэдэгдэл, нэмэлт мэдээлэл авах утасны дугаар болон санхүүгийн тусламжийн бичиг баримтуудын хуулбарыг авч болох вебсайтын хаягууд зэргийг багтаана. Мөн NS-ЕЕН-ийн зүгээс СТЖ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйг бүх өвчтөндөө санал болгоно.
- B. *Санхүүгийн тусламж*: Боломжит гуравдагч этгээдийн эх үүсвэрээс нөхөн төлбөрийг гаргуулахад нь өвчтөнд туслах нь NS-ЕЕН-ийн хувьд тогтсон заншил юм. Өвчтөнүүдийн холбооны эсвэл муж улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрагдах боломжтой хөтөлбөрийг тогтоох, мөн NS-ЕЕН-ийн СТЖ-д хамрагдах эрхтэй эсэхийг тодорхойлоход нь туслах зорилгоор өвчтөнүүдэд санхүүгийн зөвлөгөө өгдөг. Эдгээр тодорхойлолтын үр дүн гарах хүртэл төлбөр барагдуулалтын үйл ажиллагааг түр зогсоох боловч өвчтөний мэдүүлгийг үргэлжлүүлэн илгээх болно. NS-ЕЕН-оор дамжуулан санхүүгийн тусламж авахын тулд **Санхүүгийн тусламжийн журамд** хөнгөлөлтийн дүнг тооцохдоо ашигладаг шалгуур үзүүлэлтүүд, NS-ЕЕН-ийн зүгээс NS-ЕЕН-ийн үйлчилгээ үзүүлдэг харьяа газарт СТЖ-ыг олон нийтэд өргөнөөр сурталчлахын тулд авдаг арга хэмжээнүүд, санхүүгийн тусламж авах эрхтэй эсэхийг тогтоохын тулд NS-ЕЕН-ийн хэрэгжүүлдэг үйл явц, өргөдөл гаргах үйл явцын талаар дэлгэрэнгүй тайлбарласан болно.
- C. *Төлбөрийн төлөвлөгөө*: NS-ЕЕН нь төлбөр тооцоогоо төлөхөд хүндрэлтэй байгаа өвчтөнүүдэд хүүгүй, уртасгасан хугацаатай төлбөрийн төлөвлөгөөг санал болгодог.
- D. *Төлбөр төлөөгүй нөхцөлд тооцоо барагдуулах үйл ажиллагаа*: Төлбөр төлөөгүй нөхцөлд, тооцооны үлдэгдэл, гуравдагч этгээд төлбөр төлөгчийн нөхөн төлөх үүрэг хариуцлага, өвчтөний засгийн газраас тэтгэмж эсвэл санхүүгийн тусламж авах боломж, эрх, өвчтөний хамтран ажиллаж буй байдал, өр төлбөрийн ба найдваргүй зээлийн түүх, мөн өвчтөнийг тогтоох боломжгүй байдал зэрэгт үндэслэн төлбөр барагдуулалтын янз бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Төлбөр барагдуулалтын үйл ажиллагаанд гуравдагч этгээд төлбөр төлөгчийн төлбөр төлөхөөс татгалзсан гомдол, гуравдагч этгээд төлбөр төлөгчтэй харилцах дэс дараалсан харилцаа, санхүүгийн тусламж үзүүлж, төлбөр төлөхийг хүссэн өвчтөнд өгсөн мэдэгдэл, захидал, утасны дуудлага, болон өвчтөн төлбөр тооцооны үлдэгдэлтэй бөгөөд өвчтөний төлөх ёстой дүнгийн талаар өвчтөнд мэдэгдсэн анхны мэдэгдлээс хойш 120 хоногоос хэтрэхгүй хугацаанд төлбөр барагдуулалтын албанд байршуулах ёстой талаар өвчтөнд мэдэгдэх эцсийн мэдэгдэл зэрэг үйл явц багтаж болно. Мөн төлбөр тооцоог барагдуулаагүй хугацаа хэтрүүлсэн гуравдагч этгээдийн эсрэг NS-ЕЕН-ийн зүгээс хууль ёсны арга хэмжээ авч болно.
- E. *Найдваргүй авлага*: Төлбөр тооцооны нэхэмжлэхийг боломжит гуравдагч этгээд төлбөр төлөгч болон өвчтөн/батлан даагч руу илгээж, төлбөр тооцооны дүнг тогтоож, дараа дараачийн харилцаа үүсэж, санхүүгийн тусламжийн хүртээмжтэй байдлын талаар өвчтөнд мэдэгдэхийн тулд хангалттай хүчин чармайлт гаргаж, төлбөрийн хугацаа дуусаж, төлбөр тооцоо төлөгдөх боломжгүй хэмээн тогтоогдсоны дараа л тооцоог найдваргүй авлагын данснаас хасаж болно. Төлөгдөх боломжгүй гэж тогтоогдсон төлбөр тооцоонуудыг NorthShore Нэгдсэн тооцооны алба, Swedish Hospital Санхүүгийн үйлчилгээний төв, NCH Санхүүгийн зөвлөх, EEN Санхүүгийн тусламжийн хэлтэст тогтмол хугацаагаар хүргүүлдэг бөгөөд гуравдагч этгээд төлбөр барагдуулалтын албанд шилжүүлэх ажлыг түргэсгэхийн тулд цаг тухайд нь хасахыг зөвшөөрнө.
- F. *Хөндлөнгийн төлбөр барагдуулалтын үйл ажиллагаанууд*: Зөвхөн бүрэн гүйцэт нэхэмжлэх гаргаж, төлбөр барагдуулахын тулд хөндлөнгийн байгууллагад хандах гэх мэтээр төлбөр барагдуулах арга хэмжээг зохих түвшинд хийж гүйцэтгэсний дараа л зөвхөн зохих тооцоонуудыг найдваргүй өрнөөс хасахын тулд Санхүүгийн үйлчилгээний баг өвчтөний найдваргүй авлагын хасах бичилтийг хянаж, батлуулна. Тогтсон төлбөр барагдуулалтын шалгуур ба батлагдсан хасах бичилтийг зөвшөөрөх хязгаарт тулгуурлан, NorthShore Нэгдсэн тооцооны алба, Swedish Hospital Санхүүгийн үйлчилгээний төв, NCH Санхүүгийн зөвлөх, EEN Санхүүгийн тусламжийн хэлтэст бичилтийг батлах, зохих үйл ажиллагааг санал болгохын аль нэгийг сонгож, шийдвэрийг гаргана. (Тогтсон төлбөр төлөгч, үлдэгдэл ба төлбөрийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдэд тулгуурлан өвчтөний тооцооны системээр төлбөр тооцоог төлбөр барагдуулалтын хөндлөнгийн байгууллага руу автоматаар шилжүүлдэг).
- G. *Хэрэгжилт*: Энэхүү журмын хэрэгжилтийг хангах, хэлтсийн үйл ажиллагааны дүрэм журмыг гаргах ажлыг NorthShore Нэгдсэн тооцооны алба, Swedish Hospital Санхүүгийн үйлчилгээний төв, NCH Санхүүгийн зөвлөх, EEN Санхүүгийн тусламжийн хэлтэст хариуцна.

#### 5. ХАВСРАЛТ:

Байхгүй

**6. АНГИЛАЛ:**

Захиргааны удирдамжийн гарын авлага

**7. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАРИУЦАХ ЭТГЭЭД:**

Тэргүүн дэд ерөнхийлөгч, Бизнесийн алба

**8. ИШ ТАТСАН ЗҮЙЛС:**

Дотоод

Гадаад

Захиргааны удирдамжийн гарын авлага: Санхүүгийн тусламжийн журам

Дотоод орлогын код 501(r) хэсэг

**9. ШИНЭЧЛЭХ:**

Байгууллага нь хуулийн хязгаарлалтын хүрээнд үндэслэлтэй мэдэгдэл хүргүүлэн эсвэл эс хүргүүлэн энэхүү журмын нөхцөлүүдийг дангаараа хянан засварлах, өөрчлөх, хянах, өөрчлөх эрхтэй.

**10. БАТАЛСАН:**

Грег Арнольд (Greg Arnold)  
Гарын үсэг

Тэргүүн дэд ерөнхийлөгч, Бизнесийн алба  
Албан тушаал

2023/1/6  
Огноо

**11. ОГНОО:**

Гарал үүсэл: 6/2023 Хяналт: 2023/6 Хүчин төгөлдөр: 2023/6 Дараагийн хяналт: 2026/6